

КОМИНТЕРНЫ ТӨЛӨӨЛӨГЧ Т.РЫСКУЛОВ МОНГОЛД

Д. Дашдулам

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: Энэхүү өгүүлэгтээ Монгол оронд Коминтерний төлөөлөгчөөр ажиллаж байсан Т.Рыскуловын талаар өгүүлсэн юм. Т.Рыскулов нь ажиллах хугацаандаа МАН болон ЗХУ-ын Бүрэн эрхт төлөөлөгч нартай хувийн болон ажил хэргийн хувьд тун тааламжгүй харьцаатай байсан учраас КИГХ-оос удалгүй гэдрэг татсан байдаг.

Түлхүүр үг: Монгол Ардын хувьсгалт нам, Коминтерны төлөөлөгч, намын дүрэм, Төв Хороо, Дорнодын хэлтэс, залуучуудын эвлэл, Бага хурал, Үндсэн хууль, намын дүрэм, хөтөлбөр

Монгол оронд зүүний үзэл санааг тээн авчирч, хүчээр тулгаж хэрэгжүүлэгсэд бол тухайн үед Коминтерны төлөөлөгчөөр Монголд томилогдон ажиллаж байсан Т.Рыскулов, М.Амагаев, ЗХУ-ын харъяат Элбэгдорж Ринчино нар болон дараа дараагаар ээлжлэн ирсэн Коминтерны төлөөлөгчид болон ЗХУ-ын бүрэн эрхт төлөөлөгчид байлаа.

Эдгээр хүмүүсээс Э.Ринчино, М.Амагаев нарыг Улсын Бага хурлын гишүүн болгосон явдал нь тэднийг өөрсдийнхөө үзэл санааг чөлөөтэй тулгах, улмаар Улсын Бага Хурал, Засгийн газраас батлан гаргасан тогтоол шийдвэрүүдийг үзэл баримтлалдаа тохируулан засамжлах бололцоог бүрдүүлсэн ажээ.

Коминтерны төлөөлөгчөөр Т.Рыскулов нь 1924 оны 10-р сарын 6-ны өдөр Монголд ирсэн бөгөөд түүнийг цэргийн жагсаал хийн угтан авч мөн өдрийнхөө 14 цагт МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчид КИГХ-ны төлөөлөгчийг хүлээн авч хуралджээ. Уг хурал дээр Т.Рыскуловоос өөрийн биеийг Коминтернээс МАН-ыг удирдан сургах учраас тус газар төлөөлөн, илгээснийг илтгэх КИГХ-ны үнэмлэхийг үзүүлэн сүр хүчийг гайхуулж “Рыскулов би болбоос харъяат Коминтерны төлөөлөгч, Дундад Ази тивийн хэрэг эрхлэгчийн туслах”¹ хэмээн айлджээ.

МАН-ын Төв Хорооны дарга Ц.Дамбадаржаас Т.Рыскуловын үнэмлэх бичгийг орчуулан танилцуулсан байдаг. Үүнийг доор сийрүүлбэл:

“Бүх дэлхийн үгээгүй нар нэгдэгтүн. Коминтерны Гүйцэтгэх Хорооны Дорнод хэлтсээс. Үнэмлэх бичиг шийтгэн олгосон учир, эдүгээ Коминтерны гүйцэтгэгч хорооны тэргүүлэгч гишүүдийн хурлын тогтоолын ёсоор нөхөр Рыскуловыг тус хэлтсээс Монголд суух Коминтерны төлөөлөгчид зааврыг гүйцэтгэн, басхүү Ардын хувьсгалт нам ба залуучуудын эвлэл хоёрын хоорондох хэрэг явдлыг нийлүүлэхийн тулд томилон явуулав. Тэргүүлэгч гишүүн Мануильский Дорнод хэлтсийн дарга Войгинский. 1924 оны сентябрь хэмээх есөн сарын 16-ны өдөр, Москва. Дугаар 820. Коминтерны албан бичгийн газраас”² гэжээ.

Коминтерны төлөөлөгч Т.Рыскуловоос уг хурал дээр хэлсэн үгэндээ өөрийг нь ирүүлсэн зорилго, баримтлах бодлогыг тун ч тодорхой өгүүлсэн байдаг. Тэрбээр: “Миний биеийг харъяат Коминтернээс тус намын аливаа хэрэг үйлд тусалцуулахын тулд Төв Хорооны дэргэд суулгах өөрийн төлөөлөгчөөр томилон илгээсэн учир коммунист интернационалаас олгосон зааврын ёсоор танай намын аливаа гүйцэтгэн явуулах үйл хэрэгт нөхөдтэй санал, хүчийг нийлүүлэн гүйцэтгэх болой. МАН-ын дотор хоёр анги этгээд байсан зүй бус этгээдийг цэвэрлэсэн нь нэн сайн манай Коминтернаас үл зөвшөөрөх газаргүй, харин нам ба залуучуудын эвлэл завсартаа эвдрэлгүй найрамдалтайгаар

¹ МАХН-ын Төв Архив, Ц.7, Д.1, ХН.4, 1 дэх тал

² МАХН-ын Төв Архив, Ф.4, Д.1, ХН 372, 35 дах тал

хүчнээ нэгтгэн хамтатгаж эл их гүйцэтгэлээ бэхжүүлэн цааш үргэлжлүүлэн бүтээх буй за хэмээн найдмой. Коминтерн болбоос тус намын сахилга журам ба бат нэгдлийг нарийн чанга болгон сайжруулж хөгжүүлэн бататгах явдлыг урьтал болгон гүйцэтгүүлэхээр захисан бөгөөд намын удирдах ёс журам ба захиргааны захирах баримтлах ёс явдлын харилцан өөр хоёр анги ялгавартай байх ба явуулах хэрэгтэй болохыг журамлуулахын гадна Монголын нам болбоос Коминтернтэй бүрэн эрхтэй гишүүн болохыг хичээвээс зохимой”³ хэмээжээ.

Энэ нь барууны илрэл хэмээгдэн буруушаагдсан С.Данзан нарын үйл хэргийг хэлсэн бөгөөд хойшдоо аливаа зүйлд нэг ангийг баримталсан бодлого явуулахыг зааварлажээ. Мөн өдрийн Намын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 37-р хурлаас Т.Рыскуловын хэлсэн санааг тусгасан таван зүйл бүхий тогтоолыг баталсан байдаг.

Коминтерны төлөөлөгч МАН-ын Т.Рыскуловын ирсэн үе МАН-ын дарга С.Данзан, Засгийн газрын нарийн бичгийн дарга Ж.Баваасан нарыг буудан алсаны дараахантай давхцсан төдийгүй нам, эвлэлийн хоорондын харилцаа хурцдаж түүнийг яаралтай зохицуулах шаардлагатай болсон тун ээдрээтэй хэцүүхэн цаг байлаа. Монголын улс төрийн дотоод зөрчил хурцдахад Коминтерн, КИМ-ийн зүгээс идэвхтэй нөлөөлсөн төдийгүй тэдний ажлын уялдаа сулхан, төлөөлөгчдийн харилцаа, тэдний хоорондын үл ойлголцох байдал, бие биенийгээ захирах гэсэн хандлагаас гадна төлөөлөгчдийн хувийн араншин ихээхэн нэрмээс болж байлаа.

Тиймээс Ерөнхий сайд Б.Цэрэндорж “Орос, Буриад нарын удирдлагаар эвлэл ажиллаж байна”⁴ хэмээн хатуу зэмлэсэн байдаг. Залуучуудын эвлэлийн гишүүдийн болчимгүй, эрээ цээргүй үйлдлийн илэрхийлэл нь намын III их хурлын ажиллагаа болон С.Данзан, Ж.Баваасан нарыг баривчлах үед тодхон гарсан юм. Э.Ринчиногоос залуучуудын эвлэлийн хэдэн төлөөлөгчийг зөвлөх эрхтэйгээр оролцуулах санал тавьсаны дагуу Ө.Бадрах, Гонжоон, Ж.Гомбожав нарыг оролцуулсан байдаг. Тэд нар ч өөрсдийг нь ямар зорилготой, яах гэж оруулсаныг ч сайн мэдээгүй бололтой байдаг. Үнэндээ залуучуудын эвлэлийн байгууллага нь намын туслагч бэлтгэл хүчин гэхээсээ илүү эрх мэдэл булаалдсан залуучуудын бүлэглэл байсан гэхэд хилсдэхгүй болов уу. Тийм ч учраас нам, эвлэлийн хоорондын тэмцлийг зогсоох үүднээс Коминтернээс удаа дараа ирүүлсэн захидалд МАН нь улс төрийн гол хүчин бөгөөд залуучуудын эвлэл нь түүнд туслах үүрэгтэйг анхааруулсан байдаг.

Коминтерны төлөөлөгч Т.Рыскулов Монгол орноо арван сар гаран ажиллахдаа арав гаруй удаа дээд газартаа илтгэл бичсэн байдаг. Түүний бичсэн хамгийн эхний илтгэл 1924 оны арваннэгдүгээр сарын 2-нд бичсэн байх бөгөөд нам, эвлэлийн харилцаа, намын ээлжит зорилт, засгийн газар, намдаас явуулж байгаа ажлууд, улс тунхаглах, үндсэн хууль болон Бага Хурлын талаар тодорхой саналаа бичсэн байдаг.

Т.Рыскуловаас нам, эвлэлийн дотоод зөрчлийн шалтгааныг тайлбарлахдаа: “Залуучуудын эвлэл нь бүр анхнаасаа л ард түмний дотор нэвтрэн орж хувьсгалын нарийн түвэгтэй бөгөөд хар, бор ажил хийх үзэл санаагаар хүмүүжигдээгүй засгийн эрх булаан авч, засгийн эрх барьсан нам болж хувираад дараа нь ард түмэнд алив нэг сайн сайхан зүйл авчрах гэсэн эрмэлзэлд л бүх анхаарлаа төвлөрүүлсэн байлаа. Төрийн байгуулалтын талаар эвлэлийн удирдагчид үнэхээр туршлага багатай, хүн амын доторхи хүчний харилцааг сайн мэддэггүй туйлбартай бус ажил хийж байсан байна. Жишээ нь нөхөр Старков бичсэн нэг материалдаа Залуучуудын эвлэлийг

³ МАХН-ын Төв Архив. /НТА/ Ф.1, Д.2, ХН 34, 1-4 дэх талууд

⁴ МАН-ын III их хурал, Дэлгэрэнгүй тэмдэглэл, УБ, 1966, 180 дах тал

нүүдэлчдийн нам гэж үзээд, харин Ардын намыг суурин байдаг тайж язгууртны нам гэж үзсэн байв”⁵ хэмээн шүүмжилжээ. Нам эвлэлийн удирдлагад төдийгүй тэднийг онол, арга зүйн хувьд чиглүүлэх үүрэгтэй төлөөлөгчид нь ийм үзэл баримтлалтай байсан тул нам, эвлэлийн хооронд зөрчилдөн, самуурах нь гарцаагүй байлаа.

Мөн тэрбээр илтгэлдээ: “... бүр эртнээс намын шугамаар нам ба төрийн байгуулалтын ажлын гүнд орох ёстой байсан бөгөөд жилийн өмнөөс, бүр түүнээс ч эрт намыг ямар нэгэн хэмжээгээр хатуужсан, бидэнд үнэнч нам болгон хувиргахыг хичээж улмаар түүгээр дамжуулан Монголын хэрэг явдлыг удирдах ёстой байсан юм”⁶ байр сууриа илэрхийлжээ. Энэ нь нэг талаар Т.Рыскуловын санаа бодол гэдэг нь ойлгомжтой ч Коминтерны туйлын зорилготой ч авцалдаж байлаа. Коминтерн С.Данзан нарыг замаасаа зайлуулж устгасанаар МАН-ыг өөрсдөдөө үнэнч нам болгон хүмүүжүүлж Монголын хэрэг явдлыг цаашид удирдах бололцоо хангагдана гэж тооцоолсон нь харин ч талаар болж улам ээдрээтэй болох дүр зураг харагдах болжээ.

Ер нь намын дотоод зөрчил гэдэг нь албан тушаал, эрх мэдлийн төлөө, бие биенийхээ дээр гарахыг эрмэлзсэн атгаг санаа нь ил тод илэрч, хэрүүл маргаан, тэмцэл болсноос өөр юу ч биш байсан юм. Тэдний дотоод эв нэгдэлгүй зөрчилтэй байдал нь харин оросуудад дандаа “сайнаар” ашиглагдаж байлаа. Энэ талаар Т.Рыскуловоос: “Данзантаныг устгасан явдал хэдийгээр ул үндэс муутай зүйл байсан ч гэсэн энэ нь улс төрийн бодлогод барууны хэлбэрэл гаргах, хятадын мөнгө хүүлэгчидтэй холбоо тогтоох, хувьсгалын эрх ашгийн эсрэг ажиллахыг хичээгч хэн бүхэнд хатуу дохио санамж болсон юм”⁷ гэж тун тодорхой дүгнэсэн байдаг.

1924-1925 оны дунд үед холбогдох сан хөмрөгийн баримтуудад “Ардын хувьсгалт намын зүүн жигүүр” гэсэн нэр томъёо нилээд тааралддаг. Энэхүү зүүн жигүүр нь бидний тогтсон ойлголтоор П.Гэндэн, Ө.Бадрах, З.Шижээ нарын хөдөөгийнхөн буюу зүүнийхэн бус харин С.Данзан нарын эсрэг идэвхийлэн тэмцсэн залуучуудын эвлэлийн гишүүд олонх болсон Ц.Дамбадорж, Н.Жадамба, Х.Чойбалсан, Г.Гэлэгсэнгэ болон Э.Ринчино нар багтаж байжээ. 1920-оод оны дунд үеэс 1930-аад оны Монголын улс төрийн амьдралд нам түүний доторх бүлэглэлүүдийн хоорондын тэмцэл өрнөлтийн байдалтай байлаа. Хамгийн эмгэнэлтэй нь өрсөлдөгч этгээдээ улс төрийн тавцанаас хайр найргүй арчин хаяж бусдын ивээл дэмжлэгтэйгээр засгийн эрхийг авч байгаа ч хэдхэн жилийн дараа энэхүү гунигт түүх өөрсдөд нь мөн л давтагддаг юм. Магадгүй тухайн үедээ хэнбугай нь ч цаг нь болохоор ийм эмгэнэлт байдал өөрсдийнх нь толгой дээр ээлжлэн бууна чинээ бодоогүй явсан бизээ.

Т.Рыскуловын дээрх илтгэлд намын зүүн жигүүр болон гишүүдийн тухай тун сонирхолтой зүйлүүд бичигдэн үлджээ. Үүнд: “Эдүгээ намын төвүүдийг толгойлж ирээдүйтэй хэмээх нэрлэгдэх болсон хамгийн хүчтэй бүлэг бол олонхи нь аанай л Залуучуудын эвлэлээс бүрдсэн Ардын намын зүүн жигүүрийн бүлэг юм. Энэ жигүүрт Ринчино ордог бөгөөд одоохондоо бараг удирдах үүрэг гүйцэтгэж байна. Энэ бүлэг дор дурдсан хүмүүсээс бүрэлдэж байгаа юм. Үүнд: Төв Хорооны дарга Дамбадорж (залуу, орос хэл мэддэг, монголын улс төр утга зохиолын ажилтнуудын нэг, сонин сэтгүүлийн ажлыг удирддаг, цовоо сэргэлэн, ажилд харьцангуй шалмаг бөгөөд манай нөлөөлөлд дуртайяа автагдах хүн), залуучуудын эвлэлийн Төв Хорооны дарга, Улс төрийн газрын дарга Жадамба (бас л залуу орос хэл мэддэг, юманд ухамхай ханддаг, зохион байгуулах авъяас бүхий ажилтан хүн), Чойбалсан—бүх цэргийн жанжин,

⁵ Коминтерн ба монгол, УБ., 1996, 73 дах талд

⁶ Мөн тэнд, 74 дэх талд

⁷ Коминтерн ба Монгол, баримтын эмхэтгэл, УБ 1996, 75 дах тал

мөн дээрх хүмүүсийн нэгэн адил Ардын нам ба залуучуудын эвлэлийн ахмад ажилтнуудын нэг болно.

Эдгээр хүмүүс цөм Төв Хорооны Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд ордог бөгөөд бидний түшиглэж ажиллавал зохих тэр нягтарсан хувьсгалт жигүүрийг төлөөлж байгаа юм. Тэднээс гадна тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд: Хаянхярваа (лам байсан, бага зэрэг орос хэл мэддэг, ядуу гаралтай, ядуу зүдүү амьдралтай, биднийг ташаа үздэг бөгөөд бидэнд хэрэгтэй хүн), Төв Хорооны нарийн бичгийн дарга Гэлэгсэнгэ бол мөн манай талын, хувьсгалч үзэл санаатай, хөдөлмөрийн чадвартай ажилтан юм. Үлдэж буй Цэрэндорж, Гадаад яамны сайд Амар хоёр бол нэг зиндааны хүмүүс. Ринчино бол нэгэнт зүүн жигүүрийн хүн. Ардын намын энэ зүүн жигүүр Залуучуудын эвлэлийн Төв Хороо, Улс төрийн удирдах газар, нам эвлэлийн хотын байгууллагууд, хотын захиргааны удирдлагад өөрийн хүмүүсийг тавьж, мөн өөрийн хүмүүсийг аймаг хошуудын удирдлагад оруулсан болно. Зүүн жигүүрийн энэ бүлэг хэрэг дээрээ нийт залуучуудыг өөрийн талд аваад байгаа бөгөөд бусад урсгалуудыгаа бодвол хамгийн хүчтэй хувьсгалт бүлэг болж чадсан байна.

Данзантан хийгээд, эвлэлийн зүүн жигүүрийг ялсан явдал энэ бүлгийг ихэд зоригжуулсан бөгөөд тэгээд ч тэд ажилдаа идэвхийлэн ороод байгаа юм. Энэ бол хамгийн хүчтэй, ажил хэрэгч, үзэл бодлын хувьд бидэнтэй хамгийн ойр, улс орноо ардчилах намаа зохион байгуулалтын хувьд Коминтернд ойртуулахыг эрмэлздэг, бусдыгаа бодвол аливаа хоцрогдсон үзлээс хол байдаг цорын ганц бүлэг мөн гэдэгт би энд нэг сар ажиллах хугацаандаа хатуу итгэх болсон юм”⁸ гэжээ. Т.Рыскуловын нэр заан онцлон үзсэн Ц.Дамбадорж, Н.Жадамба, Х.Чойбалсан, Н.Хаянхярваа нар 1925 оны эхээр Оросын Коммунист Намд элсэх өргөдөл өгсөн⁹ боловч тэд нарт ямар ч хариу өгөөгүй бололтой.

Монголын зүүн жигүүрийнхэн хэмээн итгэл, найдвар тавиад байгаа улс төрийн хүчнийхэн хоёр гуравхан жилийн дараа “баруунтан” хэмээн адлуулж, тогтож суух газаргүй болцгоон тэднийг улс төрийн тавцанд дахин гаргахгүйгээр асуудлыг шийдвэрлэсэн байдаг.

Коминтернээс С.Данзанг устган гарч ирж буй улс төрийн шинэ хүчинд найдлага тавиад зогсохгүй өөрсдийнхөө бодлогыг саадгүй хэрэгжүүлэх бололцоо бүрэн хангагдлаа хэмээсэн нь харин ч талаар болсон юм. Тиймээс Коминтерн 1920-30-аад онд нам, эвлэлийн хоорондох зөрчлийг хурцатгах, залуучуудын эвлэлийг намын эсрэг сэргэлдүүлэх, ялангуяа асуудлын цаад урхагыг төдийлөн анзаараагүй залуучуудыг өөрийн талд татан найдвартай халаа бэлтгэх талаар бодлоготой ажиллаж байлаа. Энэ талаар 1926 оны нэгдүгээр сарын 4-нд болсон Коминтерны Гүйцэтгэх Хорооны Монголын Комиссын хурал дээр Т.Рыскуловаас: “...ардын хувьсгалт намын ерөнхий байдал дор аваачиж хянаваас үндэсний хувьсгалын ба үндэсний ардын нам болох бөгөөд мөн үүний дотор эв хамтын үзэл дор ойртох ядуучуудаас гарсан залуучууд буй тул эдний этгээд дор бага сага юм өгөх хэрэгтэй”¹⁰ гэжээ.

Үнэндээ Коминтернд ардын намын бүлэглэлтэй ажилласнаас залуучуудтай ажиллах нь илүү хялбар байсан бизээ.

Тиймээс ч зөвлөлтийн тал “залуучуудын эвлэлээс аль болох олон хүн, аль болохуйц олонтоо Орос руу илгээж манай дээд сургуулиудад суралцуулах хэрэгтэй байгаа юм. Энэ бол тэднийг орос хэлд сургах, зохих улс төрийн үзэл санаагаар хүмүүжүүлэх цорын ганц арга мөн. Засгийн дээд удирдлагад ажиллаж буй хүмүүсийг одоохондоо хэвээр үлдээж харин аль болох олон

⁸ Коминтерн ба Монгол баримтын эмхэтгэл, УБ, 1996, 76 дах тал

⁹ Монголын тухай, БХК (б) Н-ын баримт бичигт, УБ, 2002, 190 дэх тал

¹⁰ О.Батсайхан, Монгол улсын хөгжлийн замд учирсан эдлэл”, УБ, 1996, 44 дэх тал

тооны хувьсгалт залуучуудыг яамдын коллегийн гишүүн, яам, албан газруудын хэлтсийн дарга эрхлэгч болон туслахаар дэвшүүлэн ажиллуулах хэрэгтэй”¹¹ гэж үзэж байжээ.

Энэ нь нэг талаас хуучин төрийн албанд ажиллагсадын шинэ төрд ажиллах бололцоог хаах нөгөө талаас залуучуудыг дэмжин ардын хувьсгалын зорилгыг хангаж буй мэт боловч цаанаа Монгол төрийн уламжлалт залгамж холбоо, нандин ёс заншил, төрийн зүтгэлтний түүхэн хэв шинжийг өөрчлөн пролетарчлахад л чиглэгдэж байлаа.

Т.Рыскулов нь Монголд арван сар гаруй ажиллахдаа Намын Төв Хорооны Тэргүүлэгчдийн хурлуудад тогтмол сууж байсан ба аливаа асуудалд ангийн шинж чанартай хандахыг тулгаж, МАН-ын удирдлагуудтай дээрэнгүй өнгө аясаар харьцаж мөн Э.Ринчинотой таарамжгүй болсон нь асуудлыг шийдвэрлэхэд төдийгүй намын удирдлагуудын хоорондын харилцаанд шууд таагүй нөлөөлөх болжээ.

Т.Рыскуловын хэлсэн үг, боловсруулсан баримт бичгүүдийг нягтлан үзэхэд Монгол хөрснөө таарч тохирохгүй зөвлөлтийн туршлагыг шууд хуулбарлан хэрэгжүүлэхийг шаардсан байдаг. Тухайлбал Үндсэн хууль, намын дүрэм, мөрийн хөтөлбөр, намын цэвэрлэгээ, үйлдвэрчний эвлэлийг байгуулах, улсын худалдааг явуулах арга зам болон улсын анхдугаар их хурлын бэлтгэл, явц зэрэг нилээд зүйл дээр Төв Хорооны Тэргүүлэгчидтэй санал зөрж байжээ. Б.Цэрэндорж, Ц.Жамсран, Ц.Дамбадорж нар үндсэн хуульд Улсын Бага Хуралыг байгуулах хэрэггүй. Учир нь эдийн засгийн хувьд зардал чирэгдэл ихтэй, хэрэв байгуулах аваас Засгийн газарт нэгтгэн хавсруулах нь зүйтэй гэсэн байр суурьтай байжээ. Улсын анхдугаар хурал урьдчилан зохион байгуулсан хөтөлбөрийн дагуу явагдаж “үндсэн хууль баталснаар Монголын ард түмний олсон ололт, амжилтыг бататган бэхжүүлсний зэрэгцээгээр нийгмийн удирдлагын ёс журмыг цэгцрүүлэх БНМАУ-ын улс төр-соёлын хөгжлийн ирээдүйн төлөвийг тодорхойллоо”¹² хэмээн Т.Рыскулов сэтгэл ханамжтайгаар бичжээ.

Мөн түүний шууд оролцоотойгоор “1925 оны гуравдугаар сард хуралдсан МАН-ын Төв Хорооны бүгд хурал намын нэрэнд “Хувьсгалт” гэдэг үгийг нэмж оруулан МАН-ыг МАХН гэж нэрлэхээр тогтжээ. Энэ бол Коминтерны зүгээс олон жил хүсэн хүлээж байсан зүйл байв”¹³.

Удалгүй намын дүрэмд ч МАХН-ын баримтлах онол, үзэл санаа бол марксизм-ленинизм болохыг албан ёсоор намын дүрэмд тусгуулан тэдний бүтээлүүдээс монгол хэл дээр орчуулан нийтлэх ажил 1925 оноос эхэлжээ.

Энэ нь МАХН-ыг большевикчлах хүрээнд зайлшгүй хийгдэх чухал ажил байсан төдийгүй монголын нийгмийн сэтгэлгээ, олон түмний сэтгэл зүйд хурдацтайгаар тархаж байлаа.

Мөн намын хөтөлбөрийг хэлэлцэх үед тэд нараас “Энэхүү мөрийн хөтөлбөр нь Монголын байдалтай хараахан тохирохгүй хэтэрхий зүүн тийш болжээ. Хэрвээ үүний дотор дурдсан зүйлсийг гүйцэтгэх хэмээвээс Монголын хувьсгал дээш дэвших бус доош бууран унахад хүрч болмой. Юуны учраас хэмээвээс Монголын хоцрогдсон улс төрийн байдал, аж ахуй, эдийн засгийн байдал, эрдэм соёлын байдал эдгээрүүдээс Монголын олон түмнийг эрдэм чадвартай бус, төмөр замтай бус, агаарын мэдээ, төмөр утастай бус, хөгжсөн аж ахуйн үйлдвэртэй бус, ажилчин, үйлдвэрчин олон ардтай бус, харанхуй буурай нүүдэлчин болмой. Иймийн харгайгаар Монголын оронд нам ба улс төрийн байдлыг онц хэтэрхийгээр халан өөрчлөх хэмээвэл /зүүн тийш хэлбийх

¹¹ Коминтерн ба Монгол, баримтын эмхэтгэл, УБ 1996, 83 дахь тал

¹² МАХН-ын түүхийн асуудал, №10, УБ., 1974

¹³ Ч.Дашдаваа, Улаан түүх, УБ., 2003. 136 дахь тал

Д.Д/ хуучны хэрэглэгдэн байсан лам, ноёд болон шинэ, хуучин түшмэдийн этгээд, баячууд чадалтны этгээд нар нь эсэргүү хүчин болж хувьсгал лугаа эсэргүүцэн эдүүгээгийн нам засгаас аргыг хэрэглэн альханаар /аажмаар Д.Д/ хөгжин бүхий явдалд хор хүрч болмой”¹⁴ хэмээсэн байдаг.

Энэ нь нөхцөл байдлаа гүнээ мэдэрч, түмэн олон, төр улсаа хайрлан эрхт төр улсаа самууруулахаас болгоомжилж хожмын гэм, хор уршигийг эхнээс таслан зогсоохыг хичээсэн төрийн түшээгийн холч ухаанаар тунгаан гийгүүлсэн үг байлаа.

Гэвч тэдний санал, өгүүллийг Коминтерны төлөөлөгч Т.Рыскулов огтхон ч хүлээн авахыг хүссэнгүй “улам, улмаар Монгол улсын дотоод байдалтай нийлэлцэхгүй” зүйлийг хийх болсон байдаг. Тухайлбал, Т.Рыскуловаас байнгын Бага Хурлыг байгуулж “жирийн” хүмүүсийн дотроос дэвшин гарч ирсэн ямар нэг малчин ард хүнийг Бага Хурлын дарга болгох тэгэхдээ ажиллаж чадахаа амласан хүнийг сонгон авах нь зүйтэй ... ахуй амьдрал болон ангийнхаа шинж байдлаар Монгол улсын үндсэн тулгуур болсон хүн амын тэр давхраан дотроос гарсан хүн л Бага Хурлын тэргүүнээр суувал зохино”¹⁵ гэсэн байр суурьтай байжээ. Харин Э.Ринчино нь Бага Хурлын тэргүүлэгчдийн газрыг Засгийн газрын тэргүүлэгчдийн газартай нэгтгэх, Бага Хурлын даргыг намын дарга Ц.Дамбадоржоор тавих саналтай байжээ. Э.Ринчино, Т.Рыскулов хоёрын хувьд анхнаасаа таарамж муутай байсан нь үзэл бодлын гэхээсээ илүү бие биенийгээ үл хүлээн зөвшөөрч, “гол” хүн болох гэсэн улангассан байдал нь аль алинд нь хүндхэн дарамт үзүүлж улмаар хоёулангийнх нь нэр хүнд, байр сууринд муугаар нөлөөлсөн байдаг.

“Рыскуловыг Нийслэл хүрээнд ирэхэд Төв Хорооны хуралдаан залхмаар сунжирч, бид мануухай шиг суугаад Рыскулов, Ринчино хоёрын хэлмэлцэхийг өглөөнөөс орой болтол харж суудаг байлаа”¹⁶ хэмээн Н.Жадамба хэлж байжээ.

МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгч гишүүн Э.Ринчинотой эрх тушаал булаалдан тэмцэлдэх нь хэрээс хэтэрч зөрчилдөөн тэмцэл гаарах тутам Монголын удирдагчдын хоорондын харилцаанд сөргөөр нөлөөлөх болжээ. 1925 оны зургадугаар сарын 15-ны Төв Хорооны Тэргүүлэгчдийн 33-р хурал Г.Гэлэгсэнгэ, Б.Цэрэндорж, Н.Хаянхярваа, Х.Чойбалсан, Н.Жадамба, А.Амар, Б.Шийтэр, Ц.Жамсран, Д.Нацагдорж, Б.Лосол Зөвлөлтөөс Монголд суугаа элчин сайд Б.А. Васильев нарын бүрэлдэхүүнтэй хуралдаад дараах шийдвэрийг гаргажээ. Үүнд: “...Рыскулов, Ринчино нарын хоорондох тэмцэл бол Төв Хороог эвдрүүлэхэд хүрэхэд магад тул Рыскуловын биеийг татан авахыг Коминтернээс хүсэхийн хамт Ринчиног Москвад явуулахаар тогтов” хэмээн тэднийг эх оронд нь буцаах шийдвэр гаргажээ. Энэ нь тун ч зоримог бие даасан шийдвэр болсон төдийгүй Коминтерныг ч цочроосон гарцаагүй юм. Хуралд Т.Рыскулов төдийгүй тэргүүлэгч гишүүний хувьд хуралд оролцох эрх бүхий Э.Ринчиног ч оролцуулсангүй. Мөн гадаадад байсан МАХН-ын Төв Хорооны дарга Ц.Дамбадоржийн ирэхийг ч хүлээгээгүй ажээ¹⁷. Хэнээс ч хамааралгүйгээр дотоод асуудлаа өөрсдөө шийдвэрлэсэн нь магад эхний биш ч гэлээ бараг сүүлчийнх байсан гэхэд хилсдэхгүй л болов уу.

Оросын эрдэмтэн С.К.Роцины “Тэр үеийн монголын удирдагчид өөрийн гэсэн сонирхол, байр суурьтай байсан бөгөөд Коминтерны байр суурьтай нийцэж байгаа эсэхээс үл хамааран үүнийгээ айж эмээхгүйгээр хамгаалдаг

¹⁴ Ө.Бадрах “Баруун бөөрөнхийчүүдийн лүгээ амжилттай тэмцсэн их тэмцлийг туршлага”, УБ., 1932, I дэвтэр, 149 дэх тал

¹⁵ Коминтерн ба Монгол, УБ., 1996, 93 дах тал

¹⁶ Мөн тэнд, 160 дах тал

¹⁷ Ч.Дашдаваа, Улаан түүх, УБ, 2003, 149 дэх тал

байсан юм”¹⁸ хэмээн дүгнэсэнтэй санал нэг байгаа юм. Ингэж монголчууд Т.Рыскулов, Э.Ринчино хэмээх эвлэршгүй “ах” нараасаа зэрэг салж хэсэгхэн зуур чих амар, цээж тэнүүн байсан юм.

Тэд нар Монгол орноос “хөөгдөн” гарсан бөгөөд Т.Рыскулов нь Зөвлөлтийн Ардын комиссар нарын зөвлөлд харин Э.Ринчиног Дорно дахины хөдөлмөрчдийн их сургуульд /КУТВ/ ажиллуулахаар болсон байдаг. Э.Ринчино нь КУТВ-д Дорно зүгийн залуучуудыг ялангуяа монгол залуучуудыг большевик маягийн үзэл санаанд төлөвшүүлэн, итгэн бишрүүлж тэднийг ирээдүйн “их үйл хэрэгт” нь бэлтгэх болжээ.

Монголоос хөөгдөн очсон Т.Рыскуловаас 1925 оны наймдугаар сарын 13-нд КИГХ-ны Дорнодын хэлтэст Монголын байдлын талаар илтгэл тавьсан байдаг¹⁹.

Хамгийн хачирхалтай нь Дорнодын хэлтэст Т.Рыскуловын ажлын чиг шугамыг үндсэнд нь зөв хэмээн үзээд Төв Хорооны дэргэд Коминтерны байнгын төлөөлөгч суулгаж байх шийдвэр гаргаж Коминтерны дараагийн төлөөлөгчөөр М.Амагаевыг дэвшүүлсэн байдаг²⁰. Мөн КИГХ-ны төлөөлөгч, Бүрэн эрхт төлөөлөгчид бүх асуудлаар заавал зохицох заавар өгчээ.

Харин ардын намд захидал явуулахдаа Төв Хорооны чиг шугам ерөнхийдөө зөвийг тодорхойлоод, Коминтерны төлөөлөгчийн алдааг тэмдэглэн, ардын намаас ойрын хугацаанд тавих зорилтыг зааж өгөхийг тогтсон байдаг. Мөн нармай монгол гэгч хандлагын хор аюулыг тусгайлан тэмдэглэсүгэй”²¹ гэжээ.

Коминтерн монголчуудын үндэс угсаагаа эрхэмлэн, хүчирхэг, нэгдмэл байх чин хүсэлд анхнаасаа дургүйцэлтэй хандаж байлаа. Учир нь Монголын удирдагчдаас МАН-ын III их хурлын тогтоолд Дотоод Монгол, Барга, Тувагийн ард түмнийг их гүрнүүдийн эзэрхийлэл нөлөөнөөс гаргаж чөлөөлөн, бие даасан эрхийг хангахад дэмжлэг үзүүлэхээ илэрхийлж тусгай заалт оруулсан байдаг. Уг тогтоолд: “Монгол угсаатан олон аймгуудтай хэлхээ холбоо байгуулах, бүх Монголыг нэгтгэх зорилт бол бидний намын чухал зорилт бүхий гэтэл Барга, Өвөр монгол, Урианхай зэрэг бидний шашин суртлын нэгэн яс үндэсний монголчууд одоо хүртэл харилцан нэвтрэлцэж, нэгдэж чадаагүй болох тул үүнээс урагш хэрхэн харилцан нэвтрэлцэж холбоог зузаатган нэгтгэх тусгай тогтоол гаргаж оролдвол зохих учир монгол угсаатан ба нэгэн шашин суртлын этгээдийг ийнхүү бат барилдлагатай болгон нэгтгэхийг оролдох нь маш зүйтэй тул Төв Хорооноос цагийн байдал, хэргийн зүйл нийлүүлэн аль болох зохих арга зүйг эрж уг хэргийг улмаар хөдөлгөж явуулахыг хичээвэл зохино”²² гэжээ.

Коминтерны баримтлах бодлоготой Намын Төв Хорооны дээрх тогтоол зөрчилдсөн төдийгүй үүнд “ташуур” бологч нь нармай Монголын үзэлтэн Э.Ринчино гэдгийг ч сайн мэдэж байсан тул түүнд хатуухан хандаж эхлээд Хятад гоминдан намын дэргэд суух төлөөлөгчөөр явуулах шийдвэр гаргасан байдаг. Э.Ринчиног Бээжинд томилуулах саналыг Т.Рыскулов анх гаргаж Коминтерны төв удирдлагаас зөвшөөрөл хүссэн байдаг²³. Энэ хүсэлтийг 1925 оны тавдугаар сарын 6-нд тавьсан байх ба Коминтерн ч хүсэлтийг ёсоор болгох шийдвэр гаргасан бололтой. Гэхдээ учир үл мэдэгдэх шалтгаанаар долдугаар сарын эх хүртэл ямартаа ч Э.Ринчино Хятад руу явалгүй Монголд байсаар байжээ. Монголд болж буй байдал Төв Хорооноос Т.Рыскулов, Э.Ринчино

¹⁸ С.К.Рощин, Турар Рыскулов в Монголии, “Владимирцовские чтения-3”, М., 1995, с.104

¹⁹ РЦХИДНИ, ф.495, оп 154, д.236, л.17

²⁰ Коминтерн ба Монгол, УБ, 1996, 111 дэх тал

²¹ Мөн тэнд

²² МАН-ын III их хурал, УБ, 1966, 220 дахь тал

²³ РГАСПИ. Ф. 495, оп 152 д.31, л.20

нарын талаар гаргасан шийдвэр хир үндэслэлтэйг нягтлан судлуулахаар КИГХ-оос Хятадад суугаа Коминтерны төлөөлөгч Г.Н.Войтинскийг илгээсэн байдаг. Тэрбээр долдугаар сарын 6-нд Монголд хүрэлцэн ирж нөхцөл байдлыг нүдээрээ үзэж танилцжээ. Г.Н.Войтинскийгээс долдугаар сарын 9-нд Коминтерны Дорно Дахины нарийн бичгийн дарга нарын газрын дарга Ф.Петровт захидал бичжээ. Уг захидалд: Э.Ринчино, Т.Рыскуловын зөрчлийн шалтгаан нь Ринчиногийн хувьсгалч уг яриагаар халхавчлагдсан үндсэрхэг үзэл, нармай Монголын санаа бодлоос болсон хэмээн дүгнэжээ. Мөн цааш нь захидалдаа Төв Хорооны хурал дээр Э.Ринчино нь Алс Дорнодын ард түмний дунд хувьсгалт хөдөлгөөн өрнүүлэх талаар өөрийн үзэлд хэт автагдсаны улмаас Т.Рыскуловыг ямагт эсэргүүцдэг²⁴ хэмээн тэрбээр үзжээ.

Э.Ринчино Г.Н. Войтинскийг Монголд ирэхийг япон Данзангаас мэдээд түүнийг ирэхийг хүлээхээр шийджээ²⁵. Түүнд Монголд үлдэх багахан ч атугай найдлага байсан бололтой. Э.Ринчиног Зөвлөлтийн бүрэн эрхт төлөөлөгчийн газраас "цаггүй цагдан ажиглаж"²⁶ байжээ.

Г.Н.Войтинскийг оролцуулан МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 39-р хуралдаан 1925 оны долдугаар сарын 10-нд хуралдав. Хуралд Г.Гэлэгсэнгэ, Б.Цэрэндорж, Г.Хаянхярваа, Х.Чойбалсан, Н.Жадамба, А.Амар, Б.Шийтэр, Ж.Цэвээн, Д.Нацагдорж, Д.Лосол, элчин төлөөлөгч А.Васильев нарын бүрэлдэхүүнтэй оролцжээ. Хурал Коминтерны тусгай төлөөлөгчөөс ч "айж эмээхгүй" өмнөх гаргасан шийдвэртээ баттай зогссон байдаг. Түүгээр ч зогсохгүй Г.Н.Войтинскийгээс Э.Ринчиног ойрын өдрүүдэд бусад тушаалын албанаас чөлөөлөх санал гаргасан байдаг²⁷.

Ямарч найдваргүй болсон Э.Ринчино Хятад руу бус харин Москва буцахаар болжээ. КИГХ-ны 1926 оны I сарын 23-нд Дорнодын хэлтсээс гаргасан тогтоолд "Нөхөр Ринчиног үүнээс урагш Монголын хэрэгт хамаарахгүй болговол зохино"²⁸ хэмээн шийдвэр гаргасан нь Монголын удирдагчдын хүсэлтийг ёсоор болгож магнайг нь тэнийлгэсэн хэрэг болсон ажээ.

Abstract: This research paper narrates about T. Ryskulov the first representative appointed by Komintern to Mongolia. During nearly 1 year of work in Mongolia T. Ryskulov wrote more than 10 reports to Komintern. While serving his term, he played the major role in changing the Mongolian constitution and charter of the Mongolian people's Party to a bolshevik type of documents.

²⁴ РГАСПИ, ф.495, оп.152, д.31, л.26-30

²⁵ УТА. СХ. 445, д.5.хн.41,12 дах тал

²⁶ Мөн тэнд

²⁷ Коминтерн ба Монгол, УБ, 1996, 111 дэх тал

²⁸ Мөн тэнд. 126 дах тал